

“БОДЬ ДААТГАЛ” ХК-ИЙН ХЭ-ИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 сарын 12

Улаанбаатар хот

“Бодь Даатгал” ХК-ийн ХЭ-ийн ээлжит хурал 2021 оны 04-р сарын 12-ны өдрийн 11:16 цагаас [Annual general meeting \(bdsec.mn\)](http://Annual_general_meeting_bdsec.mn) Цахим хэлбэрээр болж, Хурлын даргаар Гүйцэтгэх захирал Б.Золбаяр, Санхүү эрсдэлийн удирдлагын газрын захирал Б.Билгүүн, Тооллогын комиссын дарга Б.Анхбаяр тооллогын бүрэлдэхүүн, Нарийн бичгийн дарга Ө.Батчимэг нарын бүрэлдэхүүнтэй оролцов.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ :

1. Бодь даатгал ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Б.Золбаяр: Хурлыг нээж үг хэлэн, Хурлын даргаар миний бие томилогдон ажиллаж байна. Хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя.

-Хурлын дэгийг баталсанаар танилцуулав.

-Хурлын хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Тооллогын комиссын дарга Б.Анхбаяр ирцийг танилцуулна уу?

Б.Анхбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдрийн хурал Ковид цар тахлын улмаас цахимаар явагдаж байгаа нь онцлогтой бөгөөд Би Ди Сек веб суурьтай программаар санал хураалт ирцийн дүнг гаргах юм.

“Бодь Даатгал” ХК-ийн саналын эрхтэй нийт 235,319,718 ширхэг хувьцаанаас 89,5% буюу 210,718,054 ширхэг хувьцаа эзэмшиж буй 31 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байгаа тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хүчин төгөлдөр гэж үзнэ.

Б.Золбаяр: ХЭ-н хурал нь онцгой байдлын улмаас цахим хийгдэж байгаа үүнд Би Ди Сек ХК нь хурлыг зохион байгуулахад зөвлөхөөр хамтран ажиллан оролцож байгаа иймд харилцагчийн менежер Б.Онон хурлын холбоос болон /www.dans.mn/ хаягын талаар танилцуулгыг хийнэ үү.

Б.Онон: Хурлын холбоосын танилцуулгыг Хувьцаа эзэмшигч нарт танилцууллаа.

Б.Золбаяр: Санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны талаар, 2021 оны санхүүгийн төсөөллийг танилцуулна.

Ердийн 14 даатгалын компани үйл ажиллагаа явуулдаг. Бодь Даатгал ХК-н хувьд 2019 онд нийт хураамж 27.9 тэрбум байсанаас 2020 онд 33.8 тэрбум болж аудитлагдсан дүнгээр өөрчлөгдсөн байна. Цэвэр хураамж 14 тэрбум байсанаас 14.7 тэрбум болж 4,5 хувиар өссөн үзүүлттэй байна. Хосолсон харицаа 2019 онд 101% байсан бол 2020 онд 105% болсон байна. Цар тахлын улмаас хязгаарлалтанд орж байгаа ч бид цахим хэлбэрээр өөрийн үндсэн үйл ажиллагааг явуулж байна. Орлогын үзүүлэлтийн хувьд нийт хураамж, цэвэр хураамж, цэвэр ашиг гэж хуваан 3 жилээр харицуулан авч үзсэнээр нийт хураамж давхар даатгалын нэмэгдсэн дүнгээр өөрчлөлт орж байгааг та бүхэн харж байна. Давхар даатгалын хувьд 2020 оны байдлаар 1,2 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлсэн. Нөгөө талаар гадагшаа шилжүүлж байгаа дүнгээс 600 сая төгрөгийг дотооддоо авч үлдсэн амжилттай ажиллаж байна. Санхүүгийн үр дүнгийн хувьд мөнгөн хөрөнгө 10 тэрбумаас 14 тэрбум болж өссөн байгаа үүний үр дүн нь олон нийтэд хувьцааг санал болгож хөрөнгийг татан төвлөрүүлсэн юм. Цэвэр

хөрөнгө 25 тэрбум болж нэмэгджээ. Орлогын тайлангын хувьд 2,1 тэрбумын ашигтай ажилласан байна. Цэвэр хураамжийн орлогод голлох 3 бүтээгдэхүүн болох албан журмын даатгал 4%, тээврийн хэрэгслийн даатгал 14%, эрүүл мэндийн даатгал 37% нэмэгдүүлсэн үзүүлэлтэй байна. Харин хөрөнгийн даатгал -3% , хариуцлагын даатгал -15%, мал амьтадын даатгал -26%, буурсан байна.

Бид онлайн даатгалын үйлчилгээг 2020 оны эхнээс эрчимтэй нэвтрүүлж 11 даатгалын бүтээгдэхүүнийг онлайнгаар гүйцэтгэж хэрэглэгч харилцагчид үйлчилж байна.

2021 оны төсөөллөөр бид цэвэр хураамж 18-20 т.б, цэвэр ашиг 2,5-2,8 т.б хүргэх зорилго тавин ажиллаж байна.

Дунд хугацааны санхүүгийн үзүүлэлтийг Б.Билгүүн захирал танилцуулна.

Б.Билгүүн: Олон улсын валютын сангаас эдийн засгийг 3-5 жилдээ нэлээн өөдрөгөөр харж байгаа. Иймд бид фронт оффисоо тэлэхээр ажилаа эхлүүлсэн ба 2021-2023 онуудад өндөр өсөлттэй ажиллах боломжтой гэж харж байна. Мөн цахим технологи бүтээмжийг сайжруулах нь зардлаа одоогийн түвшинд барисанаар ашигт ажиллагаа хурдтай нэмэгдэхээр харж байна.

Б.Золбаяр: Хурлын дэгийн дагуу дараагийн хэлэлцэх асуудал болох ТУЗ-н дүгнэлтийг бүрэн уншиж танилцуулав.

Бодь даатгалын хувьд дараах гол үзүүлэлттэй гарсан байна. Цэвэр хураамжийн орлого 4.5% өсч 14.7 тэрбум хүрсэн нь салбарын 11.7% эзэлж байна (+1% өнгөрсөн оноос). Үүнээс ойролцоогоор 45% орчим дараа жилд нөөцөлж, өмнөх оны нөөцөөс орлогод тооцон авч нийт 14.76 тэрбум төгрөг орлогод тооцож авсан байна.

Даатгуулагчийн хураамжийг нөхөн төлбөрт нөөцлөх хугацаанд олсон хөрөнгө оруулалтын орлогын өгөөж 13.2% байна. 2019 онд мөн ойролцоо 13% байсан. Цэвэр хөрөнгө 8%-иар өсч, давхар даатгагчтай холбоотой тооцоог оруулсан нийт хөрөнгө 0.3% буурсан байна.

Давхар даатгал орсон нийт хураамж 33.82 тэрбум буюу салбарт эзлэх хувь хамгийн өндөр 17% орчим эзэлж байна. Давхар даатгалд зуучилсан хураамжаас авсан комиссын орлого 29% өсч 1.16 тэрбум төгрөг хүрсэн нь салбарын нийт давхар даатгалын комиссын орлогын 70% гаруй хувийг эзэлсэн байна. Мөн томоохон гэрээнүүдийн өөрийн хариуцах хэсэг 5% орчим хувьд эхний байдлаар оролцож эхэлсэн байна.

Ингээд үр дүнд нь цэвэр ашиг өнгөрсөн онд салбарын 10%-ийг эзэлж байсан бол 11%-ийг эзэлж байна. ТУЗ-ийн зүгээс компанийг зорьсон ашиг орлогодоо хүрээгүй, дунд түвшинд ажилласан гэж дүгнэж байна.

Хувьцаа эзэмшигчдийн асуулт хариулт санал хэлэх үйл ажиллагаа дуусч санал хэрхэн өгөх зааварчилгааг өгөн санал хураах үйл ажиллагаа эхлэв.

Тооллогын комиссын дарга Б.Анхбаяр тооллогын шийдвэрийг танилцуулав.

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 89,4% буюу 210,650,603 ширхэг хувьцаатай 14 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгч ирц 99,9 % байв.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99,9 % зөвшөөрсөн, 0 % татгалзсан, 0 % түдгэлзсэн, 0,1 хувь нь санал өгөөгүй байна.

Тус асуудалд хүчинтэй санал өгсөн Хувьцаа эзэмшигчдийн 99,9 хувийн саналаар ТУЗ-н дүгнэлт батлах асуудлыг хүлээн зөвшөөрч шийдвэр гарав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Бодь даатгал ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1-т заасны дагуу баталсугай.

12:31 цагт Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолын шийдвэрийг танилцуулан, хурлын дарга хурлыг хаав.

Хурлын дарга :

Б.Золбаяр

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ө.Батчимэг

